


БАТЛАВ ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА  Ч.ЧИМИДСҮРЭН

“Татварын ач тус” гар зургийн уралдааны удирдамж

Монголын татварын алба 2025 оны "ТАТВАР ТӨЛӨГЧДИЙН ӨДРҮҮД"-ийг угтан ирээдүйн татвар төлөгч хүүхэд багачуудын татварын тухай мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилгоор 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 04 дүгээр сарын 25-ны өдрийг дуустал ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд бага анги 1-5 дугаар анги, дунд анги 6-9 дүгээр анги, ахлах анги 10-12 дугаар анги гэсэн 3 насны ангиллаар ТЕГ болон "Монголтакс ТМЗ" ХХК-тай хамтран гар зургийн уралдаан зарлаж байна.

Уралдаанд оролцогч нь “Татварын ач тус” сэдвийн хүрээнд татвар төлөх нь Улс эх орны хөгжилд ямар ач холбогдолтой тухай зургаар илэрхийлсэн байна. Бүтээлийг шалгаруулахдаа уралдааны сэдвийн хүрээнд агуулгыг энгийн, зөв, ойлгомжтой илэрхийлсэн эсэх, зургийн ур чадвар зэргийг харгалзан татварын албадаас томилогдсон уралдаан зохион байгуулах, шалгаруулах комисс дүгнэж байр эзлүүлнэ.

Уралдаанд оролцогч нь бүтээлийн нэр, холбогдох дугаарын хамт 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс 04 дүгээр сарын 25-ны өдрийн 23 цаг 59 минутаас өмнө өөрийн харьяа татварын албанд цахимаар ирүүлнэ. Татварын албад бүтээлийг ирсэн дарааллаар нь өөрийн нийгмийн сүлжээний хаягт байршуулж, оролцогчийн хаяг, утасны дугаарыг нийтлэхгүй байна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн уралдаан дүгнэх комисс ирүүлсэн бүтээлүүдээс 04 дүгээр сарын 27-ны өдрийн дотор насны ангилал тус бүрээс шалгарсан 1 бүтээлийг ТЕГ-ын Олон нийттэй харилцах төвд ирүүлнэ. Шалгарсан бүтээлийг Монголын татварын албаны “ТАЗИ” пэйж хуудсанд 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс 05 дугаар сарын 02-ны өдрийг дуустал байршуулж олон нийтэд танилцуулна. Бүтээлийг байршуулахдаа оролцогчийн мэдээллийг нууцалсан байна.

ТЕГ-аас томилогдсон уралдаан дүгнэх комисс нь ирсэн бүтээлүүдээс насны ангилал тус бүрээр шилдэг 3 бүтээл шалгаруулж, олон нийтийн хамгийн их хандалт авсан 1 бүтээлийг шалгаруулж, урамшуулна. Уралдааны шагналыг Татвар төлөгчдийн өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд олгоно.

Шагнал урамшуулал 3 насны ангилал тус бүрт:

Нэгдүгээр байр	-Талархал, 200.000 төгрөг
Хоёрдугаар байр	-Талархал, 150.000 төгрөг
Гуравдугаар байр	-Талархал, 100.000 төгрөг
Хамгийн их хандалт авсан нэг бүтээл	Талархал, 150.000 төгрөг

Бүтээлийг татварын албаны цахим хуудас болон албаны социал хаягуудаар алдаршуулна. Уралдаанд оролцсон бүтээлийг Татварын ерөнхий газрын “ТАЗИ” пэйж хуудсанд байршуулж, сурталчилгааны зориулалтаар ашиглана.

Татварын ерөнхий газрын Олон нийттэй харилцах төв